



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/100

Сүхбаатар сум

Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", 30 дугаар зүйлийн 30.1.17, 39 дүгээр зүйлийн 39.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам батлах тухай" 195 дугаар тогтоолын хавсралтын 5.1-5.8, Засгийн газрын 2019 оны "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 157 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Үнэлгээний, Устгалын, Худалдан борлуулж, улсын орлого болгох асуудал хариуцсан комиссыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх зөвлөлийн тусгай дансыг Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу нээж, ашиглах арга хэмжээ авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д даалгасугай.

3.Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам батлах тухай" 195 дугаар тогтоолын 2.1, 2.2, 2.3, 2.5 дах заалтуудыг хэрэгжүүлж, үнэлгээ тогтоож, шинжилгээнд хамруулсан эд зүйлсийг холбогдох материалыг бүрэн бүрдүүлэн харьяа нутаг дэвсгэрийнхээ Засаг даргын зөвлөлд хүргүүлэхийг эрх бүхий албан тушаалтнуудад даалгасугай.

4.Журмын 2.2-т зааснаар эрх бүхий албан тушаалтан нь Зөвлөлийн харьяаллыг прокурорын байгууллагаар тогтоолгосны дараа харьяа зөвлөлд хандахыг анхааруулсугай.




5.Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгсх, устгах журам батлах тухай” 195 дугаар тогтоолын 2.11, Засгийн газрын 2005 оны “Журам батлах тухай” 238 дугаар тогтоолын 4.1 дэх хэсэгт тус тус зааснаар согтууруулах ундааг сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд хүргүүлэн шийдвэрлүүлэхийг эрх бүхий албан тушаалтнуудад даалгасугай.

6.Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам батлах тухай” 195 дугаар тогтоол, 2019 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 157 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, тайлан, мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж ажиллахыг орон тооны бус Зөвлөлийн даргад даалгасугай.

7.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөл байгуулах тухай” А/37 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

8.Авлига, ашиг сонирхол, ёс зүй, санхүүгийн зөрчил, дутагдалгүй ажиллахыг зөвлөл, комиссын дарга, гишүүдэд анхааруулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ


Аймгийн Засаг даргын 2020 онь 03 дугаар  
сарын 30 -ний өдрийн А/100 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл,  
хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах,  
хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн

- Зөвлөлийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн  
хэлтсийн Захиргааны эрх зүйч, эрх зүйн сургалт,  
сурталчилгаа, хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн  
хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн  
сангийн хэлтсийн дарга
  - Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
дарга
  - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
  - Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга
  - Аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн шалгах тасгийн  
дарга
  - Аймгийн Гаалийн газрын нягтлан бодогч, гаалийн улсын  
байцаагч



Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар  
сарын 30 -ний өдрийн 1/100 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



Үнэлгээний, Устгалын, Худалдан борлуулах асуудал,  
хариуцсан комиссын бүрэлдэхүүн

Үнэлгээний комиссын дарга:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
төрийн сангийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга

-Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч

Гишүүд:

-Аймгийн Татварын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,  
төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан  
бодогч

Устгалын комиссын дарга:

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Нарийн бичгийн дарга

-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын  
байцаагч

Гишүүд:

-Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг  
хамгаалах тасгийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх  
зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг  
үйлчилгээний албаны дарга

Худалдан борлуулж, улсын  
орлого болгох комиссын дарга:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх  
зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хуулийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

-Гаалийн газрын улсын хяналтын ахлах байцаагч

-Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах  
байцаагч